



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 08/03

Эрдэнэт

Баг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Баян-Өндөр сумын Эрдэнэ багийг хувааж Чингэл; Яргуйт багийг хувааж Баян-Овоот; Цагаанчулуут багийг хувааж Найрамдал, Чандмань багуудыг тус тус шинээр байгуулж, хавсралтаар баталсугай.

2.Шинээр байгуулагдсан багуудын иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг 2022 оны 11 сард багтаан зохион байгуулахыг Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Э.Эрдэнэбат), Засаг дарга (Б.Баасансүрэн) нарт даалгасугай.

3.Шинээр байгуулагдсан багуудын шаардагдах зардлыг 2023 оны төсөвт тусган батлуулж, ажиллах нөхцөл боломжоор хангах арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

079110440

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022
оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Ээлжит
VIII хуралдааны 08/03 тогтоолын хавсралт



ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН БАГ,
ТЭДГЭЭРИЙН БАЙРШИЛ

№	Багийн нэр	Байршил	Өрх, хүн амын тоо
1	Чингэл баг	Эрдэнэ багийн: Хабитатын хэсгийн 23-р гудамж, Хабитатын 244 байшин, Сэлбийн хэсгийн 15-р гудамж, Бүстийн хэсгийн 25-р гудамж	648 өрх, 2563 хүн ам
2	Баян-Овоот баг	Яргуйт багийн: Овоотын хэсгийн 1-34-р гудамж, Хөтөлийн хэсгийн 1-13, 25-36-р гудамж	798 өрх, 3150 хүн ам
3	Найрамдал баг	Цагаанчулуут багийн: 7А хорооллын 3-13-р байр, Жаргалант хэсгийн 1-5-р гудамж	540 өрх, 2024 хүн ам
4	Чандмань баг	Цагаанчулуут багийн: 7-р хорооллын 1-8, 110, 112-р байр, Эко хорооллын хэсэг	459 өрх, 1475 хүн ам